



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот


Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай" 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам", Монгол Улсын Засгийн газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэн батлах тухай" 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам батлах тухай" А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалын Амарбал овогтой Нямдашд холбогдох хэсгийг Лутбаяр овогтой Өнө-Эрдэнэ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Манчестерийн Их сургууль, барилгын инженер, 4 жил, Түвшинбат овогтой Энхтүвшинд холбогдох хэсгийг Бүрэнтөгс овогтой Энэрэлт, АНУ, Жоржийн Технологийн Их сургууль, химийн инженер, 5 жил, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/319 дүгээр тушаалын Амарсайхан овогтой Нямрэнчинд холбогдох хэсгийг Энхбат овогтой Оюут, Канад улс, Торонтогийн Их сургууль, санхүү, 4 жил гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Г.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

001295